



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2021 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 16

Мандалговь

Хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Санхүүгийн хяналт, аудитын албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2,640,000 /хоёр сая зургаан зуун дөчин мянга/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй 8 нэр төрлийн 9 ширхэг хавсралтад дурдсан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга (Г.Зоригт)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

- 2.1 Эд хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор акталж, устган данснаас хассаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх.
- 2.2 Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны дүгээр сарын
Амгний өдрийн тогтоолын хавсралт

Санхүүгийн хяналт, аудитын албаны актлах хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Ашиг лалтад орсон огноо	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хуримтлаг дсан элэгдэл	Үлдэг дэл өртөг	Данснаас хасах болсон шалтгаан	Актлах гөрөл 1. устгах 2. худалдах 3. сэлбэг материал, хоёрдогч түүхий эд болгон 4. ашиглах
1	Samsung 1660 принтер	2010	ш	1	100,000	100,000	100,000	0	Ашиглалтын хугацаа дуусч, эвдэрсэн	1
2	Суурин компьютер DELL	2010	ш	1	450,000	450,000	450,000	0	Ашиглалтын хугацаа дуусч, эвдэрсэн	1
3	Зөөврийн компьютер MGM	2013	ш	1	200,000	200,000	200,000	0	Ашиглалтын хугацаа дуусч, эвдэрсэн	1
4	Зөөврийн компьютер DELL	2010	ш	2	200,000	400,000	400,000	0	Ашиглалтын хугацаа дуусч, эвдэрсэн	1
5	Зөөврийн компьютер TOSHIBA	2014	ш	1	200,000	200,000	200,000	0	Ашиглалтын хугацаа дуусч, эвдэрсэн	1
6	Удирдлагын ширээ	2011	ш	1	100,000	100,000	100,000		Ашиглалтын хугацаа дуусч, эвдэрсэн	1

7	Санхүүгийн программ	2015	ш	1	750,000	750000	750000	0	Ашиглах хугацаа дууссан, албан хэрэгцээнд ашигладаггүй	1
8	Санхүүгийн программ	2016	ш	1	440,000	440,000	440,000	0	Ашиглах хугацаа дууссан, албан хэрэгцээнд ашигладаггүй	1
Нийт дүн				9	2,440,000	2,640,000	2,640,000	0		